

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021.04.23

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурал, хурал хийхээр товлосон зарын дагуу 2021.4.23 ны өдрийн 14 цагт Компанийн хурлын танхимд онлайнаар болов.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2021.04.23 ны өдрийн "Хүчин төгөлдөрт тооцох тухай" №01 тоот тогтоолыг тооллогын комиссын дарга Б.Гантуяа уншиж танилцуулав. / Уг тогтоолыг хурлын материалынр хуудсанд хавсаргав./

Тооллогын Комиссын дарга Б.Гантуяа : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 1.023.73 ширхэг хувьцаа эзэмшсэн 3971 хувьцаа Эзэмшигчдээс саналын эрх бүхий ширхэг хувьцаа эзэмшсэн 60 хувьцаа эзэмшигч бүртгэгдсэн байна. Энэ нь нийт хувьцааны 71,4% -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн "Хурал хүчин төгөлдөрт тооцсугай" гэв.

Үүний дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурал дарга Л.Янжин хөл хорионоос ирж чадаагүй учир гүйцэтгэх захирал М.Базар-Ууган хурлыг нээж үг хэлэв.

Хурлын дарга : Дэлхий дахинд тараад буй Ковид-19 хар тахлаас үүдэн олон хүнийг нэг дор цуглуулахгүйгээр онлайнаар, халдвар хамгааллын дэглэмийг сахиж энэ удаагийн хурлыг зохион байгуулж байна. Хувьцаа эзэмшигч та бүхнийг "Талх Чихэр" ХК-ийн пэйж хуудсанд хандан онлайнаар саналаа өгөхийг урьж байна гэв. Дараа нь хурлын дэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга болон тооллогын комиссыг танилцуулж ажилдаа орохыг урив.

Хурал даргалагч Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны төсвийг батлах
4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 225 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор :

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2021 оны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал М.Базар-Ууган илтгэв.
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг компанийн эдийн засагч Ундармаа тайлагнав.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн товч намтар болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны төсвийг танилцуулав.

Үүний дараа компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай холбоотой асуултуудыг уншиж хариулт авав.

Асуулт: Ногдол ашгийг хэзээнээс өгөх вэ?

Хариулт: Ногдол ашгийг 2021 оны 10-р сарын 01 ний өдрөөс нэгж хувьцаанд 225 төгрөгөөр хуваарилахаар шийдвэрлэсэн. Энэ дагуу олгоно.

Асуулт: Ковидын улмаас түүхий эд материал, валютын ханш, импортоор авдаг сэлбэг, хэрэгсэл, тээвэрлэлтийн зардал өссөн нь компанийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байгаа байх, түүнийг хэрхэн даван туулж байна вэ?

Хариулт: Дэлхий дахинд учраад байгаа цар тахлаас үүдэн улс орон, байгууллага, хувь хүнд учирч байгаа бэрхшээлүүд манай компанид мөн адил учирч байна. Гэхдээ үйлдвэрлэлийн түүхий эд болох гурилыг нөөцөлсөн, хэмнэлтийн горимд шилжсэн, түгээлтийн авто машины тоог ажиллаж байна. Үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Асуулт: Яг бодитоор учраад байгаа хүндрэл бэрхшээл байна уу?

Хариулт: Цар тахлын улмаас Хөдөө орон нутаг, цэцэрлэг, сургуулийн борлуулалт тодорхой хэмжээнд тасалдаж хүргэх, зарим худалдааны төв хаагдах, ажиллах цаг богиноссон, ажилчдын ирэх буцах тал дээр хүндрэлүүд гарч байна. Иймээс борлуулалтыг тасалдуулахгүйг хичээн ажиллаж байна.

Асуулт: 2021 онд цар тахлын дэгдэлт хүндэрвэл ямар арга хэмжээ авч ажиллах вэ?

Хариулт: Цаг үеийн гөхцөл байдалтай уялдуулан халдвар хамгааллын арга хэмжээ, дэг журмыг сайжруулах талаар тушаал гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна, үүнийг үргэлжлүүлнэ, ариутгал халдваргүйтэлийн бодисын нөөц байна, түр тусгаарлах байр бэлдсэн.

Хурлын дарга : Өөр санал хүсэлт хэлэх хүн байна уу? Байхгүй бол санал шүүмжлэлээ таслая. Та бүхний үнэтэй саналыг бид сонслоо, тэмдэглэлд тусгагдаж байгаа болно, хойшдын ажилдаа мөрдлөг болгоно, та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга Б.Гантуяа "Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах тухай" тогтоолыг уншиж танилцуулав./ уг тогтоолыг хурлын материалын..... хуудсанд хавсаргав

Тооллогын комиссын дарга Б.Гантуяа : Компанийн нийт 1,023,703 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3.971 хувьцаа эзэмшигчдээс хуралд 731.542 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 60 хувьцаа эзэмшигч оролцов

Тооллогын комисст ирсэн саналын хуудас 60 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын тоо 731.530, асуулга тус бүрээр хүчингүй саналын тоо 12 байна.

1. Компаний 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн 731.530 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.

2. Компанийн 2021оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 731.530 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.

3. ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

1. Х.Баттуулыг сонгохыг зөвшөөрсөн 732.840 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.
2. Д.Цэнддоржийг сонгохыг зөвшөөрсөн 731.219 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,96 хувь, татгалзсан ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,04 хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.
3. Б.Оюунмааг сонгохыг зөвшөөрсөн 731,919 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.
4. Францисс Ли Бун Кимийг сонгохыг зөвшөөрсөн 730.919 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,92 хувь, татгалзсан 0,08 ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.
5. Х.Цэндбаярыг сонгохыг зөвшөөрсөн 732.788 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.
6. Н.Мөнхцэцэгийг сонгохыг зөвшөөрсөн 731.328 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,97 хувь, татгалзсан 0,03 ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.

ТУЗ ийн хараат бус гишүүнээр:

7. Л.Дамдинсүрэнг сонгохыг зөвшөөрсөн 730.919 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,92 хувь, татгалзсан 0,08 ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.
 8. Х.Гиймааг сонгохыг зөвшөөрсөн 730.919 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,92 хувь, татгалзсан 0,08 ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.
 9. Б.Баярсайханыг сонгохыг зөвшөөрсөн 730.919 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,92 хувь, татгалзсан 0,08 ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.
- * 2021 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 51.240.000 батлахыг зөвшөөрсөн 731.530 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.

4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 225 төгрөгөөр хувиарлахыг зөвшөөрсөн 731.530 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ хувь, түдгэлзсэн ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ хувь ирснийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ: Дээрх хэлэлцсэн асуудлаар Тогтоол гаргуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай гэж танилцуулав.

Тооллогын Комиссын дүнг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас №01 тоот тогтоол гаргав.

ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ ийн өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй
2. Компанийн 2021 оны бизнесийн төлөвлөгөөг баталсугай.
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - Х.Баттуул
 - Х.Цэндбаяр
 - Б.Оюунмаа
 - Н.Мөнхцэцэг
 - Д.Цэнддорж
 - Францисс Ли Бун Ким

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр :

- Х.Гиймаа
 - Д.Баярсайхан
 - Л.Дамдинсүрэн нарыг 3 жилийн хугацаагаар сонгосугай.
4. Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг 51.240.000 төгрөгөөр баталсугай.
 5. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 225 төгрөгөөр тогтоосугай гэж уншиж танилцуулсанаар хурлын ажиллагаа өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА :

Л.ЯНЖИН

ТЭМДЭГЛЭСЭН :

И.ӨЛЗИЙБАЯР

